



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1998 оны 3 дугаар
сарын 16 өдөр

Дугаар 6-50

Улаанбаатар
хот

Дүрэм баталж, ажнд томилох
тухай

Нэг. "Автомашин ашиглах талаар авах арга хэмжээний тухай" нийслэлийн Засаг даргын 1998 оны А-13 дугаар захирамжийг үндэслэн нийслэлийн Халамжийн автобаазын дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

Хоёр. Халамжийн автобаазын даргаар Сэрдамбын Зоригтбатыг 1998 оны 03 дугаар сарын 1-нээс томилон ажиллуулсугай.

Гурав. Халамжийн автобаазын үйл ажиллагааг аж ахуйн тооцоон дээр ажиллуулах талаар хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллахыг Нийслэлийн Нийгмийн халамжийн алба (н.Эрдэнэбаатар)-нд үүрэг болгосугай.

Дөрөв. ЭМНХ-ын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн хамтарсан 1997 оны А/329, А/195 дугаар тушаал захирамжийн "Нийслэлийн түргэн тусламж, халамжийн авто бааз" УҮГ-ын дүрэм, нэрээс "халамжийн" гэдэг үгийг хасч "Нийслэлийн түргэн тусламжийн авто бааз" УҮГ болгон өөрчилсүгэй.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Ж.НАРАНЦАЦРАЛТ

"НИЙСЛЭЛИЙН ХАЛАМЖИЙН АВТОБААЗ" АЖ АХУЙН ТООЦООТОЙ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР (УҮГ)-ЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. "Нийслэлийн халамжийн автобааз" (цаашид авто бааз гэнэ)-ыг Нийслэлийн нийгмийн халамжийн байгууллага, халамжийн төвүүд, эрүүл мэнд, боловсрол болон төр захиргааны байгууллага, иргэдэд аж ахуйн ба зорчигч тээврийн үйлчилгээг зориулалтын автомашинаар дагнан гүйцэтгүүлэх зорилгоор аж ахуйн тооцоон дээр үйл ажиллагаа явуулахаар байгуулав.

"НХАБ" нэртэй төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын үйл ажиллагааг энэхүү дүрмээр зохицуулна.

1.2. Автобааз нь Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт оршино.

1.3. Автобааз нь бие даасан тайлан тэнцэлтэй, өөрийн нэрийн өмнөөс эрх эдэлж, үүрэг хүлээх хуулийн этгээд мөн. Автобааз нь гадаад худалдааны үйл ажиллагаа бие даан явуулах эрхтэй.

1.4. Автобааз нь банк, санхүү, статистикийн байгууллагад эдгээрээс тогтоосон журмын дагуу мэдээ тайлан гаргаж өгөхийн дээр үйл ажиллагааныхаа үр дүнг хэвлэн нийтлүүлэх үүрэгтэй.

Автобааз нь улсын бүртгэлийн газарт бүртгүүлэн улсын бүртгэлийн гэрчилгээ авсан өдрөөс эхлэн үйл ажиллагаа явуулах эрхтэй болно.

Автобааз нь өөрийн нэр бүхий тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр. Үйл ажиллагааны чиглэл

2.1. "НХАБ" аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар нь үндсэн зорилгоо хэрэгжүүлэх доорхи үйл ажиллагааг явуулна. Үүнд:

1. Нийслэлийн дүүргүүдийн халамжийн төвүүд, түүнтэй ижил төрлийн байгууллагуудад автомашинаар үйлчлэх.

2. Нийслэлийн эрүүл мэнд, боловсрол, төр захиргааны зарим байгууллагуудын аж ахуйн болон хүн тээврийн үйлчилгээ

3. Бусад байгууллага, иргэдэд ахуйн болон зорчигч тээврийн үйлчилгээ

4. Үйлдвэрлэл, үйлчилгээгээ өргөтгөх чиглэлээр өөр төрлийн үйлдвэрлэл үйлчилгээг эрхлэх тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэр (зөвшөөрөл)-ийг авна.

Гурав. Дүрмийн сан

3.1. Нийслэлийн халамжийн автобаазын дүрмийн сангийн хэмжээ 92.7 (ерэн хоёр сая долоон зуун мянган) сая төгрөг болно. Үүнд:

а/Үндсэн хөрөнгө 92,7 сая төгрөг
б/Эргэлтийн хөрөнгө

3.2. Дүрмийн санг өөрчлөх шаардлагатай тохиолдолд Нийслэлийн Өмчийн газрын шийдвэрийг удирдлага болгоно.

Дөрөв. Удирдлага

4.1. "Нийслэлийн халамжийн автобааз"-ын өдөр тутмын үйл ажиллагааг Нийслэлийн Засаг даргын захирамжаар томилогдсон захирал (дарга) удирдана.

4.2. Захирал нь Нийслэлийн Өмчийн газартай гэрээ байгуулна. Гэрээнд дараах нөхцөлийг тусгана.

- 1. Төрийн Өмчийн тухай хууль, энэхүү дүрмээр заагдсан эрх үүрэг
- 2. Эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж хүртэх түвшин
- 3. Техник, технологийг шинэчлэх даалгавар
- 4. Хамт олны хөдөлмөр хамгаалал, нийгмийн талаар авах арга хэмжээ
- 5. Менежментийн бодлого
- 6. Захирал болон төрийн төлөөллийн байгууллагын харилцан хүлээх үүрэг
- 7. Үйлдвэрт өмчлөгчөөс олгосон эд хөрөнгө, түүний хэмжээ
- 8. Цалин, нэмэгдэл хөлс, урамшуулал
- 9. Ажлын нөхцөл, нийгмийн асуудал (унаа, холбоо г.м)
- 10. Эд хөрөнгийн хариуцлага
- 11. Гэрээний үүргийн биелэлтийг дүгнэх журам, түүний хугацаа
- 12. Бусад нөхцөлүүд

4.3. Захирал гэрээгээр тохиролцсон үүргээ биелүүлээгүй нь хүндэтгэн үнэх бодит шалтгаангүй бол түүнийг ажлаас халах үндэслэл болно.

4.4. Захирал дараах эрх үүрэгтэй.

1. Үйлдвэрийн газрыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх, өөрийн байгууллагын өмч хариуцагчид итгэмжлэл олгох.

2. Үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг хууль, гэрээ дүрмэнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах.

3. Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах.

4. Үйлдвэрийн газрын захиргааны бүтцийг тогтоож, албан тушаалтныг томилж, чөлөөлөх, эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох.

5. Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, технологийн нууцад хамаарах мэдээллийг тогтоох.

6. Хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцсэн хөдөлмөрийн дотоод журам баталж мөрдүүлэх.

7. Тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж, нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах.

8. Маргаантай асуудлаар үйлдвэрийн газраа төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргах.

9. Улсаас хатуу тогтоосноос бусад бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний үнэ тарифыг тогтоох.

10. Эрх хэмжээнийхээ асуудлаар хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг биелүүлэхийн тулд тэдгээрт нийцүүлэн өөрийн автобаазын хэмжээнд дагаж мөрдөх тушаал, заавар гаргах.

11. Захирал шаардлагатай мэргэжилтэн, албан тушаалтныг оролцуулсан захирлын зөвлөл байгуулан ажиллуулж болох ба зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг захирлын тушаалаар батлана. Зөвлөлийн гишүүд захиралд гагцхүү зөвлөх эрхтэй ажиллана.

12. Захирлын гэм буруутай үйл ажиллагаа болон гэрээнд заасан эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэтрүүлэн буюу урвуулан ашиглах зэргээр байгууллагад хохирол учруулсан бол уг хохирлыг өөрийн хувийн өмчийн эд хөрөнгөөр бүрэн хариуцна.

Тав. Санхүү, бүртгэл тайлан

5.1. Нийслэлийн халамжийн автобааз нь орлогоороо зарлагаа нөхөх зарчмаар аж ахуйн тооцоон дээр ажиллана.

5.2. Автобаазын эдийн засгийн үйл ажиллагаа нь жил бүрийн үйлдвэрлэл, үйлчилгээ, түүний үр ашгийг тусгаж, нийслэлийн Өмчийн газраар батлагдсан бизнес төлөвлөгөөний дагуу явагдана.

5.3. Эд хөрөнгийн талаар эдлэх эрх, үүрэг.

1. Баазын мэдлийн үл хөдлөх хөрөнгийг дүрмэнд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах.

2. Үндсэн хөрөнгийг хуульд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах.

3. Үйлдвэрлэсэн үйл ажиллагааны үр дүнд олсон ашгаас эрх бүхий байгууллагаас баталсан нормативт хэмжээгээр өөртөө үлдээж захиран зарцуулах.

4. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ өөрөө бие даан борлуулах.

5.4. Автобааз нь үндсэн хөрөнгийг зөвхөн нийслэлийн Өмчийн газрын зөвшөөрөлтэйгээр данснаас хасах буюу борлуулж устгана.

5.5. Монгол улсын хууль тогтоомжийн дагуу орлогын болон бусад татвар хураамжийг төлнө.

5.6. Тогтоосон журам зааврын дагуу нийслэлийн Өмчийн газар, Татварын алба, санхүүгийн байгууллагад тайланг гаргаж, хугацаанд нь хүргүүлэх үүрэгтэй.

5.7. Ерөнхий нягтлан бодогч нь мэргэшсэн байх бөгөөд, нийслэлийн Санхүүгийн хэлтэстэй зөвшилцсэний үндсэн дээр захирал (дарга) томилно.

5.8. Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтанд бүртгэлээр тавих хяналтыг ерөнхий нягтлан бодогч хариуцна.

5.9. Өмч хөрөнгийг бүртгэн авч хадгалах, түүнийг нэр төрөл, чанар бүрдлийн хувьд бүрэн бүтэн байлгах, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр тавьж олгох үүргийг захирлын тушаалаар томилогдсон эд хариуцагч хүлээнэ.

5.10.Эд хөрөнгийн дотоодын тооллогыг зохих бэлтгэлийг хангасны үндсэн дээр "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хуулинд заасан журмын дагуу явуулж тайлан тэнцэлд тусгана.

Зургаа.Автобаазын үйл ажиллагааг зогсоох.

6.1.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн захирамжаар дөр дурдсан тохиолдолд баазын үйл ажиллагааг зогсооно. Үүнд:

1.Монгол улсын хууль тогтоомжийн дагуу гэрээгээр хүлээсэн үүргээ бие лүүлээгүй буюу төлбөрийн чадваргүй зэргээс болж хариуцагчийн итгэл алдсан, шүүхийн шийдвэрээр дампуурсанд тооцож татан буугдвал автобаазын үйл ажиллагааг зогсооно.

2.Авто бааз нэгдэх, тусгаарлах зэргээр зохион байгуулалтын өөрчлөлт хийсэн.

6.2.Баазын үйл ажиллагааг зогсооход дараах үйл ажиллагааг баазын удирдлага гүйцэтгэнэ.

1.Банк болон харилцагч бусад байгууллагад мэдэгдэнэ.

2.Татан буулгах комисс байгуулж, эд хөрөнгөтэй холбогдсон асуудлыг шийдвэрлэнэ.

3.Эцсийн тооцоо хийж дууссаныг улсын бүртгэлийн газарт мэдэгдэж, автобаазыг улсын бүртгэлээс хасуулна.

4.Автобаазыг улсын бүртгэлээс хассанаар түүнийг татан буугдсанд тооцно.